

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН
2024 ОНЫ ХЭРЭГЖИЛТ**

2024 оны 11 дүгээр сарын 25

Улаанбаатар хот

Шийдвэрийн дэс дугаар	Зүйл, заалтын дэс дугаар		Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Биелэлт	Үнэлгээ, (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)	Тасарсан болон удааширч байгаа шалтгаан
1	2	3	4	5	6	7
Монгол Улсын хууль						
1	1	11.6.Яам, Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллага, нутгийн захиргааны байгууллага чиг үүргийнхээ дагуу статистикийн үйл ажиллагааг эрхэлнэ. Яамд бүтэцдээ салбарын статистикийн үйл ажиллагаа эрхлэн гүйцэтгэх нэгжтэй байна.	Статистикийн тухай /Шинэчилсэн найруулга/ 1997-06-05 Дугаар 1997.06.05	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/129 дүгээр тушаалаар баталсан “Гадаадын иргэн, харьяатын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц”-ээр тус байгууллагын хяналт-шинжилгээ хариуцсан мэргэжилтэн албан тушаалын тодорхойлолтын дагуу “Холбогдох байгууллагыг үйл ажиллагааны тоон болон статистик мэдээ, мэдээллээр хангах” албан тушаалын зорилтын хүрээнд байгууллагын статистикийн үйл ажиллагааны чиг үүргийг гүйцэтгэн ажиллаж байна.		
2	2	55.3.Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.	Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01	Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01 дүгээр хурлаар “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх “Гадаадын иргэн, харьяатын газрын төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2024 оны төлөвлөгөө”-г батлан хэрэгжилтийг хангаж ажиллалаа. “Хүний нөөцийн удирдлага, мэдээллийн тогтолцоо” цахим системд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд 2023 онд оруулсан нэмэлт өөрчлөлтийн		

1	2	3	4	5	6	7
				<p>хүрээнд гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчийн ажилласан нэг жилийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс нэг жил гурван сар ажилласанд тооцуулж, хөгжүүлэлт хийлгэх хүсэлтийг 02 дугаар сарын 16-ны өдрийн 01/357 дугаар албан бичгээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.</p> <p>Төрийн албаны хуулийн 57.2.3, Засгийн газрын “Журам батлах тухай” 160 дугаар тогтоолд заасны дагуу албан хаагчид цол олгох, хураах, хэрэглэх, мэргэшлийн зэрэг, түүний нэмэгдэл олгох журмыг байгууллагын даргын 2024 оны А/159, А/241 дүгээр тушаалаар тус тус баталсан.</p> <p>Засгийн газрын 2024 оны “Журам батлах тухай” 160 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчид албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цолны, мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журам, нэмэгдлийн хэмжээ”-г үндэслэн байгууллагын даргын 04 дүгээр сарын 29-ний өдрийн Б/105 дугаар тушаалаар албан хаагчдад холбогдох нэмэгдлүүдийг олгож эхлэв.</p> <p>Төлөвлөгөөний хүрээнд Төрийн тусгай албан хаагчийн нэгдсэн эмнэлгийн 11 төрлийн эрүүл мэндийн шинжилгээ, эмчийн үзлэгт төв байгууллагын 21 албан хаагчийг хамруулав.</p> <p>“Хөдөлмөрийн дотоод журам”-ын дагуу гэр бүлийн гишүүн нь нас барсан 2 албан хаагчид 1,320,000 төгрөгийн тусламжийг байгууллагын даргын 02 дугаар сарын 20-ны өдрийн Б/57, 05 дугаар сарын 28-ны өдрийн Б/134 дүгээр тушаалаар тус тус олгосон байна.</p>		
3	3	13.3. Визийн төвийн байршлыг тогтоох, сонгон шалгаруулах, гэрээ байгуулан ажиллах журмыг Засгийн газар батална.	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт,	Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн “Журам батлах тухай” 197 дугаар тогтоолоор Монгол Улсын визийн төвийн байршлыг тогтоох, сонгон шалгаруулах, гэрээ байгуулан ажиллах журам”-ыг баталсан.	(Хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай)	

1	2	3	4	5	6	7
			<p>өөрчлөлт оруулах тухай 2013-12-26 дугаар 2015-10</p>			
4	4	<p>8.2.1.эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;</p>		<p>Байгууллагын immigration.gov.mn албан ёсны цахим хуудасны “Алсын хараа, эрхэм зорилго, тэргүүлэх чиглэл”, “Стратеги зорилго, зорилт” цэсэд байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, холбогдох мэдээллийг байршуулан өөрчлөлтийг тухай бүр хийж байна.</p> <ul style="list-style-type: none"> - Эрхэм зорилго, алсын хараа, тэргүүлэх чиглэл: https://immigration.gov.mn/mn/vision/ - Стратегийн зорилт, зорилго: https://immigration.gov.mn/mn/stratyegi/ 		
	5	<p>8.2.2.чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг;</p>	<p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 2021-12-17 Дугаар 2022.05.01</p>	<p>Байгууллагын immigration.gov.mn албан ёсны цахим хуудсанд “Чиг үүрэг”, “Бүтэц”, “Зохион байгуулалтын нэгж”, “Хилийн боомт, орон нутаг” цэсэд холбогдох мэдээллийн өөрчлөлтийг тухай бүр оруулж, “Хилийн боомт, орон нутаг” цэсэд байгууллагын үндсэн чиг үүргийг хилийн боомт, орон нутагт хэрэгжүүлэн ажиллаж байгаа нэгжүүдийн харьяалах нутаг дэвсгэр, хариуцсан боомт, холбоо барих утас зэргийг тус тус ил тод мэдээлсэн.</p> <p>Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны А/129 дүгээр тушаалаар байгууллагын зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдөр мэдээллийг шинэчлэн байршуулав.</p> <p>“Холбоо барих” туслах цэсэд нийт албан хаагчдын овог нэр, албан тушаал, албаны цахим шуудангийн хаяг, өрөөний утасны дугаарыг байршуулсан.</p> <p>Түүнчлэн цахим хуудас, визийн мэдээлэл, гадаад харилцаа, хамтын ажиллагааны цахим шуудангийн хаяг, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь зэргийг нээлттэйгээр байршууллаа.</p> <p>Цахим хуудас: immigration.gov.mn</p>		

1	2	3	4	5	6	7
				<p>Нийгмийн сүлжээний хаяг: Гадаадын иргэн, харьяатын газар / Immigration Agency Of Mongolia Визийн мэдээлэлтэй холбоотой: visasection@immigration.gov.mn Гадаад харилцаа, хамтын ажиллагаа: foreignrelations@immigration.gov.mn</p>		
	6	<p>8.2.3.эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж;</p>		<p>Байгууллагын цахим хуудасны “Нээлттэй мэдээлэл” цэсийн “Үйл ажиллагаа” дэд цэс, “Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудит” туслах цэсэд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Үйл ажиллагааны чиглэлээр: <ul style="list-style-type: none"> -Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын 22 мэдээлэл, -Хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний 9 мэдээлэл, -Статистик тоон мэдээлэл 11, -Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн мэдээлэл 10, -Үйл ажиллагааны тайлан мэдээлэл 23, -Төлөвлөгөө 2. 2. Хүний нөөцийн чиглэлээр: <ul style="list-style-type: none"> - Сонгон шалгаруулалтын мэдээлэл 4, - Салбар зөвлөлийн мэдээлэл 3, - Тайлан 1 - Сургалтын төлөвлөгөө 1, - Авлигын эсрэг үйл ажиллагааны 2 мэдээлэл тус тус байршуулсан. 		
	7	<p>8.2.4.хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан;</p>		<p>Байгууллагын цахим хуудасны “Нээлттэй мэдээлэл”- “Үйл ажиллагаа”- “Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудит” туслах цэсэд:</p> <ul style="list-style-type: none"> - Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын тайлан 1, - Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн тайлан 1, үнэлгээ 1, дотоод аудитын зөвлөмж 1-ийг тус тус байршуулсан. 		
	8	<p>8.2.5.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан;</p>		<p>Тайлант хугацаанд байгууллагын цахим хуудасны “Нээлттэй мэдээлэл” - “Үйл ажиллагаа” - “Тайлан”</p>		

1	2	3	4	5	6	7
				туслах цэсэд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн нийт 6 тайланг тус тус нээлттэй байршуулсан.		
	9	8.2.6.үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт;		immigration.gov.mn цахим хуудасны “Хууль, эрх зүй” цэсэд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Харьяатын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Захиргааны ерөнхий хууль зэрэг 23 хуулийг байршуулсан. Засгийн газрын шийдвэр 6, Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар баталсан 5, байгууллагын даргын тушаалаар баталсан 4 буюу нийтээр дагаж мөрдөх эрх зүйн 15 актыг байршуулж, олон нийтэд ил тод, нээлттэй болголоо. Үүнээс Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийг англи, орос, солонгос, хятад, япон 5 хэл дээр, уг хуулийг дагалдан гарсан “Монгол Улсын виз олгох журам”, “Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах, албадан гаргахаас чөлөөлөх болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам”, “Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам”-ыг тус тус хятад, солонгос хэлнээ хөрвүүлэн цахим хуудасны “Хууль эрх зүй” цэсэд байршуулж, гадаадын иргэний үйлчилгээ авах эрхийг хангаж байна. Түүнчлэн энэ хагас жилд “Монгол Улсын иргэний харьяаллын асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах баримт бичгийн жагсаалт”-ын төсөлд санал авч ажиллав.		
	10	8.2.7.албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг;		Цахим хуудасны “Холбоо барих” цэсэд, байгууллагын зохион байгуулалтын нэгжийн удирдлага, албан хаагчдын нэр, албаны и-мэйл хаяг болон утасны дугаарын жагсаалтыг нэгж тус бүрээр байршуулж, тухай бүр өөрчлөлтийг оруулж байна. Мөн хуудасны “Нээлттэй мэдээлэл”-“Хүний нөөц”-“Ажлын байрны тодорхойлолт” туслах цэсэд Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 283, 284 дүгээр тогтоолоор зөвшөөрөл авч,		

1	2	3	4	5	6	7
				байгууллагын даргын 06 дугаар сарын 27-ны өдрийн А/257 дугаар тушаалаар баталсан төрийн тусгай албаны удирдах 11, гүйцэтгэх 64 албан тушаалын тодорхойлолт болон төрийн үйлчилгээний 20 ажлын байрны тодорхойлолтыг албан тушаал тус бүрээр нээлттэй байршуулсан.		
	11	8.2.8.өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ;		<p>Байгууллагын өргөдөл, гомдол хүлээн авах мэргэжилтний холбогдох мэдээлэл, цагийн хуваарь, өргөдөл, гомдол хүлээн авах сувгуудын мэдээллийг цахим хуудасны “Нээлттэй мэдээлэл”-“Үйл ажиллагаа”-“Өргөдөл, гомдол” туслах цэсэд нээлттэй байршуулж, өргөдөл, гомдол ирүүлэхдээ анхаарах зүйлс болон тавигдах шаардлага, хянан үзэхгүй байх, буцаах, шийдвэрлэх, хариу өгөх нөхцөлийг дэлгэрэнгүй тусгасан. Мөн холбоосоор Засгийн газрын “Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем” (legalinfo.mn цахим хуудас)-ээр дамжуулан Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд хөтөч хийж байна.</p> <p>Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн “Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 187 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 11-11 төвд ирүүлсэн болон иргэдээс байгууллагад шууд хандаж гаргасан өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэж, тайлант хугацаанд байгууллагын цахим хуудсанд өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн сар тутмын нийт 10 тайлан өргөдөл гомдол (immigration.gov.mn) мэдээ нийтэлжээ.</p>		
	12	8.2.9.хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл;		“Нээлттэй мэдээлэл”-“Үйл ажиллагаа”-“Статистик” туслах цэсэд гадаадын иргэдийн бүртгэл, хяналтын 11 тоон мэдээллийг танилцуулан ажиллаж байна.		

1	2	3	4	5	6	7
	13	8.2.10.мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр.		Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд тайлант онд олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр боловсруулаагүй.		
	14	8.3.1.ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл;		<p>Байгууллагын цахим хуудасны “Нээлттэй мэдээлэл”- “Хүний нөөц” дэд цэс дэх “Сул орон тоо, зар” туслах цэсэд сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтын зарыг Төрийн албаны зөвлөлийн “Шалгалтын цахим систем”-тэй холбоосоор холбогдох зарчмаар тухай бүр байршуулж байна.</p> <p>Төрийн албаны тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам, загвар батлах тухай” 25 дугаар тогтоолоор баталсан журамд зааснаар байгууллагын immigration.gov.mn цахим хуудсанд “Сонгон шалгаруулалтын зар” цэс болон зарын дагуу төрийн жинхэнэ албан хаагчаас баримт бичиг хүлээн авах shalgalt@immigration.gov.mn цахим хаягийг тус тус ажиллуулж байна.</p> <p>Тайлант хугацаанд Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-д заасны дагуу төрийн тусгай албаны удирдах 9, гүйцэтгэх 23 албан тушаалын сул орон тооны зарыг байгууллагын www.immigration.gov.mn цахим хуудас болон олон нийтийн сүлжээгээр төрийн жинхэнэ албан хаагчдаас нөхөх зарыг 7 удаа нээлттэй байршуулсан.</p> <p>Мөн дээрх сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтын зарыг Төрийн албаны зөвлөлийн www.csc.gov.mn цахим хуудсанд нээлттэй байршуулж, нийтэд мэдээлсэн.</p>		
	15	8.3.2.албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам;		Байгууллагын цахим хуудасны “Нээлттэй мэдээлэл”- “Хүний нөөц” дэд цэс дэх “Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөл” туслах цэсийн “Холбогдох хууль журам” хэсэгт албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулахтай		

1	2	3	4	5	6	7
				<p>холбоотой 3 журам, Төрийн албаны зөвлөлийн 6 зөвлөмжийг тус тус байршуулсан. Мөн сонгон шалгаруулалтын зарыг холбоосоор Төрийн албаны зөвлөлийн “open-exam” шалгалтын цахим системтэй холбосон.</p>		
	16	8.3.3.албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм;		<p>Байгууллагын цахим хуудасны “Нээлттэй мэдээлэл”- “Хүний нөөц” дэд цэс дэх “Хүний нөөцийн бодлого, хөтөлбөр” туслах цэсэд 2023 онд батлагдан хэрэгжиж эхэлсэн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ыг тус тус байршуулсан.</p>		
	17	8.3.4.хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам;		<p>Байгууллагын цахим хуудасны “Нээлттэй мэдээлэл”- “Хүний нөөц” дэд цэс дэх “Хүний нөөцийн бодлого, хөтөлбөр” туслах цэсэд байгууллагын даргын 2021 оны А/206 дугаар тушаалаар баталсан “Гадаадын иргэн, харьяатын газрын 2021-2031 онд баримтлах сургалт, хүний нөөцийн хөгжлийн бодлого”, мөн оны А/62 дугаар тушаалаар баталсан Гадаадын иргэн, харьяатын газрын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийг тус тус байршуулсан бөгөөд тайлант хугацаанд “Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах 2024 оны төлөвлөгөө”, “Гадаадын иргэн, харьяатын газрын 2024 оны сургалтын төлөвлөгөө”-г тус тус нэмж нийтэллээ. Мөн Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам, загвар батлах тухай” журмыг байршуулсан.</p>		
	18	8.3.5.хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ;		<p>Байгууллагын цахим хуудасны “Нээлттэй мэдээлэл”- “Хүний нөөц” дэд цэс дэх “Тайлан” туслах цэсэд Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн 2024 оны 1, 2 3 дугаар улирлын тайланг байршуулж, ил</p>		

1	2	3	4	5	6	7
				<p>тод мэдээлсэн.</p> <p>Байгууллагын хүний нөөцийн томилгоо, шилжилт хөдөлгөөний судалгааг улирлаар гарган egr.e-mongolia.mn цахим системд нээлттэй байршуулж байгаа бөгөөд 2024 оны 1, 2, 3 дугаар улирлын дэлгэрэнгүй судалгааг нийт албан хаагчдад танилцуулаад байна. Тодруулбал, 3 дугаар улиралд өссөн дүнгээр шинээр томилсон 26, жинхэлж томилсон 4, нэгж хооронд шилжүүлсэн 15, улсын байцаагчийн эрх олгосон 26, дэвшүүлсэн 21, төрийн үйлчилгээнээс төрийн тусгай албан тушаалын ангилал, зэрэглэлд шилжсэн 15, төрийн албанаас түр чөлөөлсөн, чөлөөлсөн, хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болсон 27, үргэлжлүүлэн ажиллуулах 5, нийт 139 албан хаагчийн мэдээллийг нэгтгэж, танилцууллаа.</p>		
	19	8.3.6.албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам.		<p>Байгууллагын цахим хуудасны “Нээлттэй мэдээлэл”- “Хүний нөөц” дэд цэс дэх “Хүний нөөцийн бодлого, хөтөлбөр” туслах цэсэд Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны “Аргачлал, загвар батлах тухай” 98 дугаар тушаалыг тус тус байршуулсан.</p>		
	20	8.4.1.өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл;		<p>Төсвийн мэдээг байгууллагын цахим хуудасны “Нээлттэй мэдээлэл”-“Төсөв санхүү, худалдан авах ажиллагаа” дэд цэс дэх “Шилэн данс” туслах цэсийг www.shilendans.gov.mn цахим хуудастай холбоосоор холбогдох зарчмаар ажиллуулан тухай бүр мэдээллийг танилцуулж байна.</p> <p>2024 оны батлагдсан төсөв болон 2023 оны 12 дугаар сар, 2024 оны 1-10 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, 2025 оны төсвийн төслийг www.shilendans.gov.mn цахим хуудсанд хуулийн хугацаанд нь байршуулсан. Шилэн дансны тухай хуулийн дагуу (өссөн дүнгээр) төсөв санхүүгийн 149</p>		

1	2	3	4	5	6	7
				мэдээ байршуулахаас хуулийн хугацаанд 149 мэдээ www.shilendans.gov.mn цахим хуудсанд байршууллаа.		
	21	8.4.2.төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан;		2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, 2024 оны хагас жилийн нэгтгэсэн санхүүгийн тайланг Сангийн яамны цахим систем болон www.shilendans.gov.mn цахим хуудсанд хуулийн хугацаанд нь байршууллаа.		
	22	8.4.3.санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт;		Үндэсний аудитын газраас 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт авсныг хуулийн хугацаанд нь www.shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулсан.		
	23	8.4.4.хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ;		Засгийн газрын 2021 оны “Улсын тэмдэгтийн хураамж, визийн үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох тухай” 195 дугаар тогтоолоор гадаадын иргэнд үзүүлсэн үйлчилгээнээс хураамж авч байгаа тухай мэдээллийг www.shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулан мэдээлж байна.		
	24	8.4.5.төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар;		2023 оны 12 дугаар сар, 2024 оны 1-10 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг хуулийн хугацаанд нь гаргаж, тайлбарын хамт тухай бүр www.shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулан ажиллаж байна.		
	25	8.4.6.таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;		Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээ, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгч 7 аж ахуйн нэгжийн мэдээллийг тухай бүр www.shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулж, ил тод мэдээллээ.		
	26	8.4.7.цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт;		Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг тухай бүр www.shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулан мэдээлж байна.		
	27	8.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа,		Тэтгэмж, урамшуулал, нэмэгдэл олгох тухай		

1	2	3	4	5	6	7
		түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;		байгууллагын даргын нийт 70 тушаалыг www.shilendans.gov.mn цахим хуудсанд хуулийн хугацаанд нь байршуулсан.		
	28	8.4.9.шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл;		Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас ирүүлсэн дүгнэлт, зөвлөмжийг www.shilendans.gov.mn цахим хуудсанд байршууллаа.		
	29	8.4.10.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендер оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендер шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;		Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны холбогдох мэдээлэл болон “2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”, тайлан, мэдээ, гэрээ, баримт бичгийг www.tender.gov.mn , www.shilendans.gov.mn цахим хуудсанд тус тус хуулийн хугацаанд бүрэн байршуулж, ил тод мэдээлсэн. Тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуулийн дагуу (өссөн дүнгээр) хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой 6 мэдээ байршуулахаас 6 мэдээг хуулийн хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд байршууллаа.		
	30	8.4.11.худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт;		Тайлант онд худалдан авах ажиллагаанд үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалт хийгдээгүй тухай www.shilendans.gov.mn цахим хуудсанд хуулийн хугацаанд нь байршуулж мэдээлсэн.		
	31	8.4.12.мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл;		Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагаас холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангуулах тухай хүсэлт тайлант онд ирүүлээгүй байна.		
	32	8.4.26.төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт,		Төсвийн хөрөнгөөр Ховд аймгийн Жаргалант суманд Гадаадын иргэн, харьяатын газрын Баруун бүс дэх газрын үйлчилгээний цогцолбор барилгыг Улсын		

1	2	3	4	5	6	7
		хэрэгжилт, явц, үр дүн;		комиссын 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн ББКД-84-33/23 дугаар дүгнэлтээр 12 дугаар сарын 15-ны өдөр ашиглалтад оруулсан үр дүнг www.tender.gov.mn , www.shilendans.gov.mn цахим хуудсанд тус тус байршуулж, гүйцэтгэлд хяналт тавин ажиллалаа.		
	33	8.4.27.мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан;		Тайлант хугацаанд байгууллагын захиалгаар судалгаа, шинжилгээний ажил хийгдээгүй болно.		
	34	8.4.28.хууль тогтоомжид заасан бусад. (8.4.Мэдээлэл хариуцагч төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:)		Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Гадаадын иргэн, харьяатын газрын төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг хуулийн хугацаанд нь www.shilendans.gov.mn цахим хуудсанд бүрэн гүйцэд байршуулж, ил тод мэдээлж ажилласан. Байгууллагын цахим хуудасны “Нээлттэй мэдээлэл”- “Төсөв санхүү, худалдан авах ажиллагаа” дэд цэс дэх “Шилэн данс” туслах цэсийг www.shilendans.gov.mn цахим хуудастай холбоосоор холбогдох зарчмаар ажиллуулан төсвийн мэдээг тухай бүр байршуулж байна.		
	35	8.5.1.үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл;		Гадаадын иргэн үйлчилгээ авахтай холбоотой асуудлаар баримт бичигт өөрчлөлт оруулах тухай бүр цахим хуудастаа ойлгомжтой байдлаар шинэчлэн байршуулж, үйлчилгээг шуурхай хүргэж байна. “Визийн зөвшөөрөл” цонхны “Виз”, “Виз сунгалт”, “Оршин суух зөвшөөрөл”, “Иргэд харилцан визгүй зорчих орны жагсаалт” цэсэд Монгол Улсын виз, Монгол Улсад оршин суух зөвшөөрлийн хүсэлт гаргахтай холбоотой бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, шийдвэрлэх хугацаа, тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл, санамжийг нийтэлсэн. Мөн Монгол Улсад визгүй зорчих орны жагсаалтыг Гадаад харилцааны яамны “consul.mn” цахим хуудаснаас холбоосоор холбов. “Иргэний харьяалал” цонхны “Хүүхэд үрчлэлт”,		

1	2	3	4	5	6	7
				<p>“Төрийн бус байгууллага”, “Иргэний харьяалал” цэсэд Монгол Улсын харьяат болох, харьяатаас гарах, иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын Монгол Улсад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын иргэн, гэр бүлд үрчлүүлэхэд мөрдөх хууль, журмын мэдээлэл, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, мэдүүлгийн хуудас, шийдвэрлэх хугацаа, тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээллийг байршуулсан.</p> <p>“Зөрчил шийдвэрлэх” цонхны “Зөрчил шийдвэрлэх”, “Гадаадын иргэнийг Монгол Улсаас гарахыг сануулах”, “Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах” цэсэд гадаадын иргэн, түүнийг уригчийн гаргасан зөрчлийг шийдвэрлэхтэй холбоотой бүдүүлэх баримт бичгийн жагсаалт, зөрчлийн зүйлчлэл, торгох шийтгэлийн хэмжээ, тэмдэгтийн хураамж, гадаадын иргэн, түүний уригчийн хүсэлтээр холбогдох төрийн байгууллагад гаргаж хүргүүлдэг зөрчил гаргаж байсан эсэх талаарх лавлагааны бүрдүүлэх материалын жагсаалт, тэмдэгтийн хураамжийн мэдээллийг байршуулсан.</p>		
	36	8.5.2.тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа.		Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/08 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт Монгол Улсад үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих журам”-ын дагуу салбар, төлөөлөгчийн газар шинээр нээх, зөвшөөрлийн хугацаа сунгах, хүчингүй болгохтой холбоотой мэдээлэл болон Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа, үйл ажиллагаа явуулах хүсэлт шинээр гаргасан, үйл ажиллагааг нь цуцалсан төрийн бус байгууллагын жагсаалтыг immigration.gov.mn цахим хуудасны “Төрийн бус байгууллага” цэс дэх “Олон улсын болон гадаад		

1	2	3	4	5	6	7
				улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газар” туслах цэсэд нээлттэй мэдээлэв.		
	37	8.6.1.олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал;		Захиргааны ерөнхий хуулийн 26, 61 дүгээр зүйлд заасны дагуу хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон актын төсөлд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас тайлбар, санал гаргах боломжийг олгох зорилгоор тайлант хугацаанд байгууллагын цахим хуудасны “Хууль, эрх зүй” цэсийн “Төсөлд санал авах” туслах цэсэд “Монгол Улсын иргэний харьяаллын асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах баримт бичгийн жагсаалт”-ын төсөлд санал авсан.		
	38	8.6.2.эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт;		Гадаадын иргэн, харьяатын газарт эзэмшиж байгаа оюуны өмчийн эрх байхгүй болно.		
	39	8.6.3.хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл;		Гадаадын иргэн, харьяатын газрын чиг үүрэгт хамаарахгүй.		
	40	8.6.4.мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл;		Гадаадын иргэн, харьяатын газрын эзэмшиж байгаа газрын мэдээллийг egazar.mn цахим системд байршуулсан.		
	41	8.6.5.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг;		Гадаадын иргэн, харьяатын газрын чиг үүрэг, үйл ажиллагаанд хамаарахгүй.		
	42	8.6.6.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх		Энэ чиглэлээр ажилладаг зөвлөл, зөвлөлийн гишүүн байхгүй.		

1	2	3	4	5	6	7
		удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл;				
	43	8.6.8.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл;		Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн шийдвэрийн дагуу үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх, данснаас хасаж актлах, үнэ шинэчлэн тогтоох зэрэг төсвийн хөрөнгийн ашиглалт, хөдөлгөөнтэй холбоотой асуудлын хүрээнд байгууллагын даргын тушаал болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрийг шийдвэр гарсан тухай бүр www.shilendans.gov.mn цахим хуудсанд ил тод байршуулан ажиллаж байна.		
	44	8.6.10.мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл;		Гадаадын иргэн, харьяатын газрын эрхлэх чиг үүрэгтэй холбоотой үйл ажиллагаа, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологид хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн шинжилгээ хийдэггүй.		
	45	8.6.11.барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт;		Ховд аймгийн Жаргалант суманд баригдсан “Гадаадын иргэн, харьяатын газрын баруун бүс дэх газрын үйлчилгээний цогцолборын барилга”-ыг Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн ББКД-84-33/23 дугаар дүгнэлт болон холбогдох бусад баримт материалыг www.shilen.gov.mn цахим системд байршуулж мэдээлсэн.		
	46	8.6.19.хуулийн этгээдийн эцсийн эзэмшигч, эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл;		Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэгт 8.6.19-д заасан мэдээллийг улсын бүртгэлийн асуудал хариуцсан		

1	2	3	4	5	6	7
				төрийн захиргааны байгууллага хариуцан нээлттэй, ил тод байлгах аар заажээ.		
	47	8.6.20.нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл;		Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 232 дугаар тогтоолоор “Нээлттэй өгөгдлийн жагсаалт”-д баталсан, байгууллагад хамаарах 6 бүлгийн 11 төрлийн нээлттэй өгөгдлийг XLSX болон XML, CSV, JSON өргөтгөл буюу машин унших формат (2024 оны 09 дүгээр сар хүртэлх)-аар тус тус боловсруулж, “Гадаадын иргэн, харьяатын газрын нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэх үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөө”-ний дагуу байгууллагын цахим хуудас болон Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн систем (opendata.gov.mn)-д тухай бүр нийтэлсэн. Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 96 дугаар тогтоолоор 2022 оны 232 дугаар тогтоолыг хүчингүй болгож, “Нээлттэй өгөгдлийн жагсаалт”-ыг шинэчлэн баталснаар уг жагсаалтын дагуу мэдээлэл хариуцагчийн сар бүр нийтлэх 11 төрлийн өгөгдлийг 10 дугаар сарын байдлаар XLSX, CSV, JSON өргөтгөлөөр тус тус боловсруулж, 11 дүгээр сарын 15-ны өдөр байгууллагын цахим хуудас болон Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн систем (opendata.gov.mn)-д төлөвлөгөөнд заагдсан хугацаанд нийтэллээ.		
	48	8.6.21.мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт;		Тайлант хугацаанд байгууллагын зардлаар албан хаагчийг суралцуулаагүй.		
	49	8.6.22.хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл.		Гадаадын иргэн, харьяатын газар нь Шилэн дансны тухай хуулийн дагуу нээлттэй байхаар заасан мэдээллүүдийг хуулийн хугацаанд нь www.shilendans.gov.mn цахим хуудсанд бүрэн гүйцэд байршуулан, ил тод мэдээлж байна.		
5	50	18.2.Хил орчмын аялал жуулчлалын	Аялал	“Монголд зочлох жил”-ийн хүрээнд Байгаль орчин,		

1	2	3	4	5	6	7
		<p>нутаг дэвсгэрт энэ хуулийн 18.1-д заасан гадаадын иргэн зорчих маршрутыг хууль зүйн болон аялал жуулчлалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.</p>	<p>жуулчлалын тухай /Шинэчилсэн найруулга/ 2023-05-04 Дугаар 2023.05.04</p>	<p>аялал жуулчлалын сайдын 2023 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн А/314 дүгээр тушаалаар байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус байгууллагаас Виз, зөвшөөрлийн газрын дарга ажиллаж, Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн “Журам батлах тухай” 142 дугаар тогтоолоор "Хил орчмын нутаг дэвсгэрийн аялал жуулчлалын үйл ажиллагааг зохион байгуулах, аюулгүй байдлыг хангах журам"-ыг баталсан.</p> <p>Аялал жуулчлалын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газраас Монгол Хятад хоёр улсын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг бэхжүүлэх, хоёр улсын хоорондын аялал жуулчлалын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх зорилгоор “Аялал жуулчлалын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдөр талууд харилцан гарын үсэг зурсан бөгөөд хилийн боомтод виз олгох үйлчилгээг түргэн шуурхай зохион байгуулах зорилгоор “e-form.mn” программ хангамжийг тус байгууллагаас энэ онд шинээр хөгжүүлэн үйл ажиллагаанд ашиглаж байна.</p>		
Хэсгийн дундаж: хувь ...						
Улсын Их Хурлын тогтоол						
6	51	<p>ХЗДХЯ УИХ-ын тогтоолын төсөл 2021. Монгол Улсад 2021-2024 онд цагаачлуулж болох гадаадын иргэдийн тоо, бүтэц, байршлын тухай</p> <p>Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 29.6-д заасны дагуу Монгол Улсад 2021-2024 онд цагаачлуулж болох гадаадын иргэдийн тоо, бүтэц, байршлыг тогтоох.</p>	<p>Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай 2021-01-22 Дугаар 2021</p>	<p>Монгол Улсад 2009-2012 онд оруулж болох цагаач гадаадын иргэдийн тоо, бүтэц, байршлын тухай Монгол Улсын Их Хурлын 2009 оны 44 дүгээр тогтоолоор жилд оруулж болох цагаач гадаадын иргэний тоог жил бүр 100-аас дээшгүй байхаар тогтоосон.</p> <p>Монгол Улсад 2013-2016, 2017-2020 онд оруулж болох цагаач гадаадын иргэдийн тоо, бүтэц, байршлыг тогтоолгохоор 2013, 2015, 2018 онд тус тус Засгийн газраас Улсын Их Хуралд тогтоолын төслийг танилцуулж байсан ч батлагдаагүй болно.</p>		

1	2	3	4	5	6	7
			№12	Гадаадын иргэн, харьяатын газраас “Монгол Улсад 2021-2024 онд цагаачлуулж болох гадаадын иргэдийн тоо, бүтэц, байршлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, танилцуулгыг 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 01/1730 дугаар, 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 01/2075 дугаар албан бичгээр тус тус Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлсэн.		
Хэсгийн дундаж: хувь ...						
Ерөнхийлөгчийн зарлиг						
7	52	3.Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай.	Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай 2018-05-23 Дугаар 2018_46	Төв байгууллага болон боомт, орон нутаг дахь нэгж тус бүрийн албаны байр нь үндэсний бичгээр хослуулан бичсэн хаягтай бөгөөд байгууллагын туг, тэмдэг, албан хаагчдын ялгах тэмдэг (жетон, ханцуй, малгайн бэлгэ, тэмдэг)-т үндэсний бичгийг оролцуулсан. Төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээний хүрээнд 03 дугаар сард орон нутагт зохион байгуулсан “Үндэсний бичгийн мэдлэг дээшлүүлэх сургалт”-д Хойд бүс дэх газрын 33 албан хаагч давхардсан тоогоор хамрагдсан. Мөн Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газраас 05 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсан “Үндэсний бичиг үсгийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх өдөрлөг” арга хэмжээнд Өмнөд бүс дэх газрын 6 албан хаагч оролцов. Ховд аймгийн Соёл, урлагийн газраас “Эх хэл соёлоо эрхэмлэе” аяны хүрээнд зохион байгуулсан “Хүмүүн бичиг-хүн бүхний бичиг” 2 дугаар шатны уралдаанд Баруун бүс дэх газрын “Гэрэгэ” баг оролцож тэргүүн байр эзэллээ. Тайлант онд Удирдлагын академийн Үндэсний бичгийн 1, 2, 3 дугаар түвшний цахим сургалтад 132 албан хаагч хамрагдаж гэрчилгээ авсан байна.		
8	53	1.5.Иргэн, аж ахуйн нэгжийн тарьсан модоор ойн санг бүрдүүлж, түүнийг улсын нэгдсэн санд бүртгэх, тарьсан	Засгийн газарт чиглэл өгөх тухай	Монгол Улсад оршин суух зөвшөөрөл хүссэн болон бүртгэл хийлгэж буй гадаадын иргэдэд Монгол оронд мод тарих тухай зөвлөмж, мэдээллийг уриалга		

1	2	3	4	5	6	7
		модыг зах зээлийн эргэлтэд оруулж энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулахад нь бодит дэмжлэг үзүүлэх болон гадаад улсаас Монгол Улсад ирж буй хүн бүр монгол оронд мод тарих санаачилгыг өрнүүлэх	/Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58	хэлбэрээр тогтмол хүргэж байна.		
	54	2.Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай.		“Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийг тохиолдуулан 05 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд төв байгууллага болон орон нутаг дахь нэгжүүд харьяалах нутаг дэвсгэртээ нийт 6 төрлийн 245 ширхэг мод, сөөг тарьж, өнгөрсөн жилүүдэд тариалсан мод, бутаа арчлан усалгаа, цэвэрлэгээг тогтмол хийж байна. Мөн 10 дугаар сарын 11, 23-ны өдрүүдэд орон нутаг дахь нэгжүүд харьяалах нутаг дэвсгэртээ нийт 3 төрлийн 1645 ширхэг мод тус тус суулгаж, арчилгаа, усалгааг хийлээ.		
Хэсгийн дундаж: хувь ...						
Засгийн газрын тогтоол						
9	55	5.Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томъёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7	“Гадаадын иргэн, харьяатын газрын 2024 оны сургалтын төлөвлөгөө”-д “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ийг хэрэгжүүлэх заалтыг оруулан баталж, төрийн албан хаагчид зориулан Удирдлагын академиас зохион байгуулж буй Үндэсний бичгийн 1, 2, 3 дугаар түвшний цахим сургалтад нийт 132 албан хаагч хамрагдаж, цахим гэрчилгээтэй дүүргэлээ. Төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээний хүрээнд 03 дугаар сард орон нутагт зохион байгуулсан “Үндэсний бичгийн мэдлэг дээшлүүлэх сургалт”-д Хойд бүс дэх газрын 33 албан хаагч давхардсан тоогоор хамрагдсан. Түүнчлэн 10 дугаар сарын 02-ны өдрөөс Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн 6 албан хаагч Монгол бичгийн сургалтад танхимаар хамрагдаж эхэллээ. Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газраас 05 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсан “Үндэсний бичиг үсгийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх өдөрлөг” арга хэмжээнд Өмнөд бүс дэх газрын 6		

1	2	3	4	5	6	7
		<p>бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.</p>		<p>албан хаагч оролцов. Ховд аймгийн Соёл, урлагийн газраас "Эх хэл соёлоо эрхэмлээ" аяны хүрээнд зохион байгуулсан "Хүмүүн бичиг-хүн бүхний бичиг" 2 дугаар шатны уралдаанд Баруун бүс дэх газрын "Гэрэгэ" баг оролцож тэргүүн байр эзэллээ. Байгууллагын гаднах хаяг, туг, байгууллагад ашиглаж буй 1 тамга, 1 тэмдэг, боомт, орон нутаг дахь нэгж тус бүрийн албаны байрны гаднах хаяг, тэмдэг, албан хаагчдын ялгах тэмдэг (жетон, ханцуй, малгайн бэлгэ, тэмдэг)-т үндэсний бичгийг оролцуулсан байна.</p>		
10	56	<p>2.Монгол Улсад 30 хүртэл хоногийн хугацаагаар жуулчлах хавсралтад дурдсан улсын иргэдийг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл Монгол Улсын визийн шаардлагаас чөлөөлсүгэй. 2.Энэ тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт даалгасугай.</p>	<p>Визийн шаардлагаас чөлөөлөх тухай 2023-01-04 Дугаар 2023_1</p>	<p>Засгийн газрын 2023 оны 01 дүгээр тогтоолоор Монгол Улсын цахим виз олгох улсын жагсаалтад багтаж байсан Европын улсууд болон Австрали, Шинэ Зеланд зэрэг 34 улсын иргэнийг визийн шаардлагаас чөлөөлснийг үндэслэн "Визийн мэдээллийн нэгдсэн сан" систем (evisa.mn)-ээс дээрх 34 улсыг хасаж, шийдвэрийг мөрдөн ажиллаж байна.</p>	Хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай	
11	57	<p>Х-1.3.Төрийн үйлчилгээний хүнд суртал, чирэгдлийг багасгах, иргэд, хувийн хэвшлийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, хамтран ажиллах.</p>	<p>2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай 2023-02-08 Дугаар 2023_49</p>	<p>Төрийн үйлчилгээний хүнд суртал, чирэгдлийг багасгах хүрээнд Монгол Улсын виз олгох үйл ажиллагааг хялбаршуулах зорилгоор Гадаадын иргэн, харьяатын газраас олгодог бүх ангиллын визийн зөвшөөрлийг бүрэн цахимжуулсан. Мөн Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 107 дугаар тогтоолоор "Монгол Улсын виз олгох журам"-ын 2.1.1-2.1.6-д заасан ангиллын визийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 2.1.7-2.1.8, 2.2-2.9-д заасан ангиллын визийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага цахимаар олгож болохоор зохицуулсан. Дээрх өөрчлөлтийн хүрээнд уригчтай 54 ангиллын визийг цахимаар олгох хөгжүүлэлтийг "Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан (isf.mn)" системд хийж,</p>		

1	2	3	4	5	6	7
				байгууллагын даргын 2024 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн А/366 дугаар тушаалаар тус үйл ажиллагааг хэрэгжүүлж эхлэв.		
12	58	1..Монгол Улсын иргэдийн Бүгд Найрамдах Солонгос Улсад зорчих нөхцөлийг хөнгөвчлөх чиглэлээр Бүгд Найрамдах Солонгос Улсын Хууль зүйн яамтай хэлэлцээ хийх, хамтран ажиллах төлөвлөгөө гарган ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг нарт тус тус даалгасугай.	Монгол Улсын иргэдийн Бүг Найрамдах Солонгос Улсад зорчих нөхцөлийг хөнгөвчлөх чиглэлээр авах арга хэмжээний тухай 2023-05-03 Дугаар 2023_166	Засгийн газрын 2023 оны “Монгол Улсын иргэдийн Бүгд Найрамдах Солонгос Улсад зорчих нөхцөлийг хөнгөвчлөх чиглэлээр авах арга хэмжээний тухай” 166 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд төлөвлөгөөний дагуу Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Бүгд Найрамдах Солонгос Улсын Цагаачлалын албаны даргатай 12 дугаар сарын 15-ны өдөр, 01 дүгээр сарын 19-ний өдөр Сөүл хотноо тус тус албан уулзалт хийсэн. Уулзалтаар иргэд харилцан адил байх зарчмыг баримтлан Монгол Улсын иргэдийг хил нэвтрүүлэлгүй буцаахгүй байх, Бүгд Найрамдах Солонгос Улсын Хууль зүйн яамнаас хэрэгжүүлдэг өршөөлийн аянд хамруулан нутаг буцаах, тус улсыг сайн дураар орхин гарсан иргэнд дахин хууль ёсоор зорчих баталгааг гаргах, Монгол Улсад Бүгд Найрамдах Солонгос Улсын Цагаачлалын байгууллагын төлөөллийг томилуулан ажиллуулах зэрэг саналыг дэвшүүллээ. Улаанбаатар хотноо 05 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулагдсан Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын Гадаад харилцааны яамд хоорондын Консулын XI зөвлөлдөх уулзалтад байгууллагын дарга оролцож, Монгол Улсын төрийн дээд албан тушаалтан, үйл ажиллагаа нь тогтвортой аж ахуйн нэгжийн удирдлага, тэдний гэр бүлийн гишүүд зэрэг олон удаагийн визийн болзол хангасан иргэдэд виз олгох хугацааг богиносгох, хууль бусаар оршин суугаа иргэд сайн дураар нутаг буцсан тохиолдолд хилээр буцаж орох баталгааг гаргаж өгөх талаар санал дэвшүүлсэн.		
	59	2..Бүгд Найрамдах Солонгос Улсын талтай хэлэлцээ хийх, хамтран ажиллах төлөвлөгөөг тохирох чиглэлээр тус улсад ажиллах монголын талын төлөөлөгчдийн бүрэлдэхүүний томилолтын болон холбогдох бусад		Бүгд Найрамдах Солонгос Улсын талтай хэлэлцээ хийх, хамтран ажиллах төлөвлөгөөг тохирох чиглэлээр тус улсад ажиллах монголын талын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд байгууллагын дарга ажиллаж байна. Арга хэмжээний хүрээнд тус улсын Цагаачлалын		

1	2	3	4	5	6	7
		зардлыг батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарт даалгасугай.		албатай 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдөр, 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр Сөүл хотноо албан уулзалт тус тус зохион байгуулсан. Албан уулзалтын томилолтын зардалд 2023 онд 4,519,560 төгрөг, 2024 онд 3,079,156 төгрөгийг зохих журмын дагуу байгууллагын төсвөөс шийдвэрлэсэн байна.		
13	60	2.Монгол Улсад үйл ажиллагаа хэрэгжүүлэх Монгол-Оросын хамтарсан сургуулийн тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулах, Оросын Холбооны Улсаас ирж ажиллах багш нарт оршин суух зөвшөөрөл олгох, аюулгүй байдлыг хангах зохих арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт тус тус даалгасугай	Хамтарсан сургууль байгуулах тухай 2023-08-30 Дугаар 2023_320	Монгол Улсад үйл ажиллагаа хэрэгжүүлэх Монгол-Оросын хамтарсан сургуулийн тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Засгийн газрын 2023 оны 320 дугаар тогтоолоор Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн ерөнхий боловсролын 162 дугаар сургуулийг Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу "Монгол-Оросын хамтарсан ерөнхий боловсролын сургууль" болгон өөрчлөн байгуулагдсан. Тайлант хугацаанд тус сургуульд ажиллах Оросын Холбооны Улсын 12 иргэнд Монгол Улсад хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл олгосон байна.		
14	61	3..3.Энэ тогтоолыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай.	Журам, жагсаалт, үнийн дүн батлах тухай 2023-12-13 Дугаар 2023_445	Тус тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Гадаадын жуулчны хувийн хэрэгцээнд зориулж худалдан авсан бараанд төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын төлбөрийн баримтыг бүртгэх, түүнд хяналт тавих журам"-ын 2.6-д заасан мэдээллийг илгээх зорилгоор 4 төрлийн сервисийг хөгжүүлэн Татварын ерөнхий газарт хүлээлгэн өгч, Төрийн мэдээлэл солилцооны ХУР системийг ашиглан мэдээлэл солилцож байна. Үүнд: 1. FS100101_personInfo (Гадаад иргэний мэдээлэл)-г 2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр, 2. FS100102_registerInfo (Гадаад иргэний бүртгэлийн мэдээлэл)-г 2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр, 3. FS100108_visalInfo (Гадаадын иргэний визийн мэдээлэл)-г 2023 оны 12 дугаар сарын 12-ны		

1	2	3	4	5	6	7
				<p>өдөр, 4. FS100110_nonGovernmentalOrganizationInfo (Салбар төлөөлөгчийн газрын мэдээлэл)-г 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр тус тус хөгжүүлэн ашиглаж эхэлсэн.</p>		
15	62	<p>3.Энэ журмыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөсүгэй. (Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах нөхцөл, бүртгүүлэх журам”)</p>	<p>Журам батлах тухай 2024-02-28 Дугаар 2024_77</p>	<p>Эдийн засаг хөгжлийн яам, Азийн хөгжлийн банктэй хамтран хэрэгжүүлж буй "МОН3936: Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл"-ийн бүрэлдэхүүн хэсэг ЗҮ-03: “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем”-ийн хөгжүүлэлтийг 2024 оноос эхэлж, журмын дагуу төслийн нэгжээс Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд холбогдох баримт, хүсэлтийг хүргүүлэн зөвшөөрөл, зөвлөмжийг авсан. https://st-backoffice.isf.mn/ Түүнчлэн үйл ажиллагаанд шинээр нэвтрүүлэхээр төлөвлөж байгаа оршин суух үнэмлэх хэвлэх “Киоск” машины программын холбогдох материалыг дээрх журмын дагуу 10 дугаар сарын 16-ны өдрийн 01/2048 дугаар албан бичгээр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд хүргүүлээд байна.</p>		
Хэсгийн дундаж: ... хувь						
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл						
16	63	<p>ХҮИИ.2.7.Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх, бэлтгэл хангах арга хэмжээ авах, үйл ажиллагааг тусгайлан зохицуулсан хөтөлбөр боловсруулж батлуулан ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт;</p>	<p>2022 оны 5 дугаар сарын 4-ний өдөр 27 дугаар тэмдэглэл 2022-05-04 Дугаар 2022_27</p>	<p>“Монголд зочлох жил”-ийн хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн А/314 дүгээр тушаалаар байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус байгууллагаас Виз, зөвшөөрлийн газрын дарга ажиллаж, Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн “Журам батлах тухай” 142 дугаар тогтоолоор "Хил орчмын нутаг дэвсгэрийн аялал жуулчлалын үйл ажиллагааг зохион байгуулах, аюулгүй байдлыг хангах журам"-ыг баталсан. Аялал жуулчлалын тухай хуулийн 18.1 дэх хэсэгт заасны дагуу хоёр улсын хоорондын иж бүрэн стратегийн түншлэлийг бэхжүүлэх зорилгоор “Аялал жуулчлалын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т</p>		

1	2	3	4	5	6	7
				<p>2023 оны 10 дугаар сарын 17-ны өдөр талууд харилцан гарын үсэг зурж, Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан хэлэлцээр байгуулснаар хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх эрх зүйн үндсийг тавьсан.</p> <p>Уг хэлэлцээрээр Монгол Улсын хил орчмын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын зорилгоор зорчих БНХАУ-ын бүлэг жуулчид хил нэвтрэх нөхцөлд 1 жилийн хүчинтэй хугацаатай олон удаагийн “орох, гарах БНХАУ-ын зорчих үнэмлэх” эзэмшигч бүлэг жуулчдын ахлагч эсхүл хөтөч-орчуулагч нь визгүйгээр Монгол Улсад нэвтрэх ба түүнийг дагалдан Монгол Улсад зорчих 3 сарын хүчинтэй хугацаатай нэг удаагийн “хил орчмын аялал жуулчлалын зориулалт бүхий орох, гарах БНХАУ-ын зорчих үнэмлэх”-тэй БНХАУ-ын бүлэг жуулчид “Нэрсийн жагсаалт”-аар Монгол Улсад нэвтэрч болохоор тохиров. Одоогийн байдлаар дээрх 1 жилийн хугацаатай, олон удаагийн болон 3 сарын хүчинтэй хугацаатай, нэг удаагийн, хил орчмын аялал жуулчлалын зориулалт бүхий зорчих үнэмлэхийн загвартай тус тус танилцаад байна.</p> <p>Хилийн боомтод виз олгох үйлчилгээг түргэн шуурхай зохион байгуулах зорилгоор “e-form.mn” программ хангамжийг тус байгууллагаас шинээр хөгжүүлэн үйл ажиллагаанд ашиглаж байна.</p>		
17	64	<p>II..Тогтоол батлагдсантай холбогдуулан “Монгол Улсын визийг цахимаар авах улсын жагсаалт”-д өөрчлөлт оруулах, гадаадын бусад улсыг нэмж хамруулах асуудлыг холбогдох байгууллагын саналыг харгалзан шийдвэрлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг нарт даалгав.</p>	<p>2023 оны 1 дүгээр сарын 4-ний өдөр 1 дүгээр тэмдэглэл 2023-01-04 Дугаар 2023_1</p>	<p>Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор зарим улсын иргэнийг визийн шаардлагаас чөлөөлснийг үндэслэн “Визийн мэдээллийн нэгдсэн сан” систем (evisa.mn) дэх бүртгэлээс хавсралтад дурдсан 34 улсыг хассан.</p> <p>Гадаад харилцааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн А/09, А/53 дугаар хамтарсан тушаалаар 98 улсыг цахим виз олгох улсын жагсаалтад нэмснийг уг системд бүрэн нэвтрүүлж, нийт 99 улсын иргэнд цахим визийг олгож болохоор зохицуулсан.</p> <p>Гадаад харилцааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн</p>		

1	2	3	4	5	6	7
	65	<p>II.3.Тогтоол батлагдсантай холбогдуулан Гадаадын иргэдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, бүртгэл, хяналтыг сайжруулах чиглэлээр зохих арга хэмжээ авч ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Гадаадын иргэн, харьяатын газар (Н.Ууганбаяр), Хил хамгаалах ерөнхий газар (Х.Лхагвасүрэн), Тагнуулын ерөнхий газар (П.Одонбаатар) нарт даалгав.</p>		<p>сайдын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн “Жагсаалтад нэмэлт оруулах тухай” А/03, А/08 дугаар хамтарсан тушаалаар Монгол Улсын цахим виз олгох улсын жагсаалтад Индонези Улсыг нэмсэн. Evisa.mn системийг үйл ажиллагаанд нэвтэрүүлснээс хойш 2021, 2022 онуудад 36 улсын 7899, 2023 онд 45 улсын 30231, 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн байдлаар 77 улсын 86802, нийт 118 улсын давхардсан тоогоор 124932 гадаадын иргэнд цахим виз олгожээ.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 01 дүгээр тогтоол болон Гадаад харилцааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/09, А/53, 2024 оны А/03, А/08 дугаар хамтарсан тушаалыг тус тус мөрдөн ажиллаж, тайлант хугацаанд Гадаадын иргэн, харьяатын газар нь “Визийн мэдээллийн нэгдсэн сан” систем (evisa.mn)-ээр нийт 86802 гадаадын иргэнд цахим виз олгосон. https://www.evisa.mn/en</p>		
18	66	<p>I.2.5.Иргэдийн зорчих нөхцөлийг хөнгөвчлөх талаар БНСУ-ын холбогдох байгууллагатай хэлэлцээ хийх үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулж, энэ хүрээнд дараах асуудлыг хэлэлцэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарт: -Монгол Улсын Засгийн газар болон БНСУ-ын Засгийн газар хооронд байгуулсан Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээрт холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах замаар харилцан нийгмийн даатгалаас чөлөөлөх хугацааг нэмэгдүүлэх, төлөгдсөн нийгмийн даатгалын буцаан олголтод хамаарах визийн ангилал хүрээг нэмэгдүүлэх;</p>	<p>2023 оны 2 дугаар сарын 20-ны өдөр 9 дүгээр тэмдэглэл 2023-02-20 Дугаар 2023_9</p>	<p>Засгийн газрын 2023 оны “Монгол Улсын иргэдийн Бүгд Найрамдах Солонгос Улсад зорчих нөхцөлийг хөнгөвчлөх чиглэлээр авах арга хэмжээний тухай” 166 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Бүгд Найрамдах Солонгос Улсын Цагаачлалын албаны даргатай 12 дугаар сарын 15-ны өдөр, 01 дүгээр сарын 19-ний өдөр Сөүл хотноо тус тус албан уулзалт хийсэн. Уулзалтаар иргэд харилцан адил байх зарчмыг баримтлан Монгол Улсын иргэдийг хил нэвтрүүлэлгүй буцаахгүй байх, Бүгд Найрамдах Солонгос Улсын Хууль зүйн яамнаас хэрэгжүүлдэг өршөөлийн аянд хамруулан нутаг буцаах, тус улсыг сайн дураар орхин гарсан иргэнд дахин хууль ёсоор зорчих баталгааг гаргах, Монгол Улсад Бүгд Найрамдах Солонгос Улсын Цагаачлалын байгууллагын төлөөллийг томилуулан ажиллуулах</p>		

1	2	3	4	5	6	7
		<p>-БНСУ-д эмчилгээ хийлгэж буй иргэдийг дэмжих зорилгоор тус улсын эмнэлгүүдийн төлбөрийн хөнгөлөлтийг эдлүүлэх болон эрүүл мэндийн даатгалд хамрагдах;</p> <p>- Хөдөлмөрийн гэрээгээр БНСУ-д ажиллаж буй монгол иргэдийн эцэг, эх, үр хүүхэд, гэр бүлийн зүгээс тус улсад зорчих виз хүсэхэд тодорхой хөнгөлөлт эдлүүлэх.</p>		<p>зэрэг саналыг дэвшүүллээ.</p> <p>Мөн байгууллагын дарга Бүгд Найрамдах Солонгос Улсын Элчин зөвлөхтэй 02 дугаар сарын 22-ны өдөр, тус улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайдтай 07 дугаар сарын 08-ны өдөр тус тус уулзан тодорхой шаардлага хангасан болон олон удаагийн виз авах болзол хангасан иргэнд визийн хянан шийдвэрлэх хугацааг богиносгох талаар хүсэлт гаргасан.</p> <p>Улаанбаатар хотноо 05 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулагдсан Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын Гадаад харилцааны яамд хоорондын Консулын XI зөвлөлдөх уулзалтад байгууллагын дарга оролцож, Монгол Улсын төрийн дээд албан тушаалтан, үйл ажиллагаа нь тогтвортой аж ахуйн нэгжийн удирдлага, тэдний гэр бүлийн гишүүд зэрэг олон удаагийн визийн болзол хангасан иргэдэд виз олгох хугацааг богиносгох, хууль бусаар оршин суугаа иргэд сайн дураар нутаг буцсан тохиолдолд хилээр буцаж орох баталгааг гаргаж өгөхийг хүсэв.</p> <p>Бүгд Найрамдах Солонгос Улсын Цагаачлалын албаны даргаар Ноён Пэ Сан Об томилогдсонтой холбогдуулан баяр хүргэж, Монгол Улсын иргэдийн зорчих нөхцөлийг хөнгөвчлөх чиглэлээр идэвхтэй хамтран ажиллана гэдэгт итгэж буйгаа илэрхийлсэн 01/1861 дүгээр албан бичгийг 09 дүгээр сарын 20-ны өдөр хүргүүллээ.</p>		
19	67	<p>ХҮИИ.8.3.Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газар, байнгын ажиллагаатай хилийн боомтод төрийн үйлчилгээний цэгийг нээхэд бүх талын дэмжлэг үзүүлж ажиллахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт.</p>	<p>2023 оны 5 дугаар сарын 03-ны өдөр 19 дүгээр тэмдэглэл 2023-05-03 Дугаар 2023_19</p>	<p>Сэлэнгэ аймаг дахь Сүхбаатар төмөр замын боомтын төрийн нэг цэгийн үйлчилгээний цогцолбор ашиглалтад орсноор Гадаадын иргэн, харьяатын газрын Хойд бүс дэх газар нь 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс тус цогцолборт үйл ажиллагаагаа эрхэлж байна.</p> <p>Засгийн газрын 2023 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 174 дүгээр тогтоолоор “Зорчигчийн мэдээллийн төв”-ийг Хил хамгаалах ерөнхий газрын дэргэд байгуулж, “Олон улсын нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээс зорчигчийн мэдээллийг</p>		

1	2	3	4	5	6	7
				<p>урьдчилан авах, харилцан мэдээлэл солилцох, түүний аюулгүй байдлыг хангах журам” батлагдсанаар байгууллагын даргын 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн Б/319 дүгээр тушаалаар Агаарын замын боомт хариуцсан газрын хяналтын улсын 1 байцаагчийг тус төвд сэлгэн ажиллуулж байсан. Тухайн байгууллагаас албан хаагчийн цалин хөлс, нэмэгдэл хөлсний санхүүжилт шийдэгдээгүй тул хоёр байгууллага харилцан тохиролцож, байгууллагын даргын 03 дугаар сарын 21-ний өдрийн Б/71 дүгээр тушаалаар хяналтын улсын байцаагчийг Агаарын замын боомт хариуцсан газарт буцаан томилов.</p> <p>Хууль зүй, дотоод хэргийн сайдын 04 дүгээр сарын 29-ний өдрийн А/133 дугаар тушаалаар байгуулсан Хил хамгаалах ерөнхий газрын дэргэдэх “Зорчигч мэдээллийн төв”-ийн чиг үүрэг, бүтэц зохион байгуулалтыг тодорхойлох, холбогдох эрх зүйн актыг судалж нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл боловсруулах, санал танилцуулах үүрэг бүхий “Ажлын хэсэг”-т байгууллагаас орон нутаг хариуцсан ахлах мэргэжилтэн ажиллаж 2 удаагийн хуралд оролцсон.</p>		
Хэсгийн дундаж: ... хувь						
Нийт дундаж: ... хувь						

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА

И.БААТАРХҮҮ

НЭГТГЭСЭН:

ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Г.ГЭРЭЛТУЯА